

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ
ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар)**

2021 оны 03 дугаар сарын 29

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын өргөдөл, гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэсэн байдал, холбогдох байгууллага, иргэн аж ахуйн нэгжид хүрсэн эсэх, зөрчил гомдлыг үндэслэн хэрхэн сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай”, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ болон ажил хариуцсан албан хаагчийн тайлбарыг үндэслэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой ажил төлөвлөж, зохион байгуулж буй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 21 хүсэлт www.erp.ulaanbaatar.mn системд бүртгэсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1 хоног 22 цаг 48 минут байна.

Ирүүлсэн өргөдөл, гомдлын дэлгэрэнгүй мэдээлэл

Хүснэгт 1

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын %
1	Ажлаас чөлөөлөх тухай	3	14.29%
2	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	1	4.76%
3	Цалинтай чөлөө хүсэх тухай	3	14.29%
4	Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	4	19.05%
5	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	2	9.52%
6	Жирэмсний амралтын тухай	4	19.05%
7	Цалингүй чөлөө олгох тухай	1	4.76%
8	Цалин хөлсний тухай	1	4.76%
9	Сургалтад хамрагдах тухай	2	9.52%
Нийт өргөдөл, гомдлын дүн		21	100.00%

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хугацаагаар авч үзвэл:

Хүснэгт 2

Ирсэн өргөдөл, гомдол	Шийдвэрлэсэн хугацаа				Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрсэн
	1-5 хоногт	6-10 хоногт	11-15 хоногт	16-30 хоногт		
Нийт 21	19	1	1	-	-	-

3.1.1 Хүснэгт 1-т дурдсан 21 хүсэлт нь газрын хүний нөөцтэй холбоотой 15, Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагаатай холбоотой 4, Сургалтад хамрагдах тухай 2 ирүүлснийг тухай бүр шийдвэрлэж хариу өгсөн байна.

3.2 Тайлант хугацаанд өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой нийт 4 зөрчил бүртгэгдсэн нь өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил байна.

Шийдвэрлэлтийн зөрчлийг нэгжээр авч үзвэл хувьд:

Хүснэгт 3

№	Хэлтэс	Өргөдлийн дугаар	Тайлбар	Зөрчлийн тоо	Зөрчлийн огноо
1	Удирдлага Г.Содбаяр	O210304095	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	1	2021.03.09
2	Захиргаа, санхүүгийн хэлтэс Д.Дөлгөөн	O210204114	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	1	2021.02.08
3	Захиргаа, санхүүгийн хэлтэс С.Ариунхишиг	O210118019	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	1	2021.01.19
4		O210118038		1	
НИЙТ 4 ЗӨРЧИЛ					

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2021 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 4.3.1-т Өргөдөл, гомдлын нэгдсэн системийг журмын дагуу хөтлөн, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацааг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэж байхаар төлөвлөсөн.


2021 оны 1 дүгээр улирлын байдлаар тус газарт 21 хүсэлт ирүүлснийг шийдвэрлэсэн дундаж хугацаа 1 хоног 22 цаг 48 минутад шийдвэрлэсэн нь дундаж хугацааг 3 хоног 4 цаг 02 минутаар багасгаж ажилласан байна. 2019 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус газар нь 16 удаагийн өргөдөл, гомдлыг дунджаар 3 хоног 13 цаг 49 минутад багтаан шийдвэрлэсэн нь 2020 оны мөн үетэй 2021 оныг харьцуулахад 1 хоног 15 цаг 01 минут хоногоор өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа багассан байна.

Цаашид хэрэгжүүлэх нь:

- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбогдох бусад дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллах:
 - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”;
 - Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоол “тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”;
 - Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль;
 - Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/252 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг” журам,

- Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” журам г.м.
- 2. Өргөдөл, гомдлыг цахим системээр ирсэн өдөрт нь багтааж цохолтын дагуу холбогдох албан тушаалтанд шилжүүлэх,
- 3. Шийдвэрлэлтийг цахим системд бүртгэхдээ монгол бичгийн дүрмийг баримтлахад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ГЭНХТАЙВАН

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Д.ДӨЛГӨӨН

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 С.РЭНЦЭНМАА

НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН

 Ц.АМАРМАНДАХ

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН
БАЙГУУЛСАН АЖЛЫН 2021 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
ТАЙЛАН**

2021 оны 03 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 2021 оны 01 дүгээр улирлын байдлаар өргөдөл, хүсэлт ирж хуулийн хугацаандаа шийдвэрлэгдсэн байна.

Өргөдөл гомдлын дэлгэрэнгүй тайлангийн хувьд авч үзвэл:

Хугацаандаа шийдвэрлэсэн - 21, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – 0, судалж байгаа 0 үзүүлэлттэй байна.

Үүнээс:

1. Гомдол - 0
2. Хүсэлт - 21

Өргөдөл гомдлын хандалтын тайлангийн хувьд авч үзвэл:

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл, гомдлын хувь
1	Цалинтай чөлөө хүсэх тухай	3	14.29%
2	Ажлаас чөлөөлөгдөх тухай	3	14.29%
3	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	1	4.76%
4	Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	4	19.05%
5	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	2	9.52%
6	Цалин, хөлсний тухай	1	4.76%
7	Цалингүй чөлөө хүсэх тухай	1	4.76%
8	Сургалтанд хамрагдах тухай	2	9.52%
9	Жирэмсний амралтын тухай	4	19.05%
Нийт өргөдөл, гомдлын дүн		21	100.00%

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлангийн хувьд авч үзвэл:

2021 оны 1-р улиралын эцсийн байдлаар байгууллагад ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1 хоног 22 цаг 48 минутад шийдвэрлэгдсэн байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:
БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

С.АРИУНХИШИГ